

МОНГОЛ УЛС
УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/155

Улаангом

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Засгийн газрын 2012 оны 222 тоот тогтоолын 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн, ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг аймагт зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Дэд зөвлөлийн дарга: Аймгийн засаг даргын орлогч

Дэд зөвлөлийн орлогч ХОХБТХ-ийн дарга

Гишүүд: СТСХ-ийн төсвийн мэргэжилтэн

БОАЖГ-ын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн

МХГ-ын уул уурхайн улсын байцаагч

МХГ-ын байгаль орчны улсын байцаагч

Аймгийн Татварын хэлтсийн дарга

Тухайн сумын засаг дарга

Тухайн сумын байгаль орчны ажилтан

Тухайн сумын байгаль хамгаалагч

Тухайн сум дахь ашигт малтмалын хайгуулын болон

ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн

төлөөлөл

Тухайн сум дахь бичил уурхайн нөхөрлөлийн төлөөлөл

Аймгийн байгаль орчны иргэний зөвлөлийн тэргүүн

Дэд зөвлөлийн нарийн бичиг - Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн Байгаль орчин, Аялал жуулчлал, уул уурхайн салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

2. Дэд зөвлөлөөс 2021 онд хийх ажлын төлөвлөгөөгөө гаргаж, төслийн ажлын албатай хамтран, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангуулж, үр дүнг хугацаанд нь мэдээлж ажиллахыг зөвлөлийн дарга / Ж.Александр /-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан, 2017 оны А/06 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.ЧИМЭД



D:\A3ДТГ\zahiramj.docx
8521020576